

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны....дугаар сарын...-ний өдөр

Дугаар.....

Буурал

Сумын дундын техник ашиглалтын  
журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.13, 48 дугаар зүйлийн 48.1, Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.2, Улсын Их хурлын 2003 оны 29 дүгээр “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого батлах тухай” тогтоол, Засгийн газрын 2017 оны 278 дугаар “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөр батлах тухай тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сумын орон нутгийн хөгжлийн сангаар авсан сумын дундын техникийг ОНӨААТҮГазар төвлөрүүлэн ашиглалтыг хариуцуулан тариаланчдад ашиглуулах талаар нийтээр дагаж мөрдөх журмыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумын Засаг дарга /Т.Атархишиг/-т, хяналт тавьж ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хороо (Б.Бээжин)-д тус тус даалгасугай.

3. Уг тогтоолыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж бүртгүүлэхийг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны дарга (Б.Мөнхбаяр)-д даалгасугай.

ДАРГА

Н.ГАНБААТАР

Хонгор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын  
202... оны ...дугаар сарын .....-ны өдрийн  
.....дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

## СУМЫН ДУНДЫН ТЕХНИК АШИГЛАЛТЫН ЖУРАМ

### Нэг. Зорилго

1.1. Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийн 3.2.1 заасан хүнсний ногоо үйлдвэрлэгчийн захиалгаар бага, дунд оврын трактор, түүнд зориулсан чиргүүл дүүжин машин, мотоблок болон түүнд сольж угсардаг үрлэгч, арчлах, хураах техникийг сумын иргэдэд ашиглуулахтай холбоотой ажлыг зохион байгуулахад тариаланч болон техник ашиглагчийн хоорондох харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Сумын техникийг ашиглагч үр, төмс, хүнсний ногооны тариалангийн үйлдвэрлэлийн механикжуулалтын түвшинг тогтворжуулах хүртээмжтэй хүргэх

1.3. Газар тариалангийн технологийн ажил болох тариалалт, арчлалт, хураалтыг хугацаанд нь чанартай гүйцэтгэх байх.

1.4. Сум дундын техникийн арчлалт хамгаалалт засвар үйлчилгээг хийхдээ сумын комисстой хамтран акт үйлдэж гүйцэтгэнэ.

1.5 Сумын газар тариалан эрхэлдэг иргэдэд Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын баталсан жишиг үнэлгээг баримтлан энэхүү журмын дагуу ашиглана.

### Хоёр. Сум дундын техникийг ашиглагчид шилжүүлэх ажлын зохион байгуулалт

2.1. Сум дундын техникийг иргэдэд ашиглуулахдаа сумын Засаг даргын санал дээр үндэслэн орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар /цаашид ОНӨААТҮГазар/ дээр тулгуурлан зохион байгуулна.

2.2. Газар тариалангийн чиглэлээр 3 ба түүнээс дээш жил ажилласан, техник технологийн ажил хийж үндсэн орлогоо олж байгаа мэргэжлийн механикжуулагч ОНӨААТҮГазарт хүсэлт гаргана.

2.3. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэрийг үндэслэн сумын Засаг дарга энэ ажлыг хэрэгжүүлэх тухай захирамж гаргаж ажлын хэсгийг томилон уг ажлыг гүйцэтгүүлнэ.

2.4. Сумын Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг нийт техникийн үзлэг явуулж коджуулан техникийн гэрчилгээ шаардагдах бичиг баримтыг бүрдүүлэн ОНӨҮГазар хүлээлгэн өгнө.

2.5. Сум дундын техник эзэмшилдээ авсан ОНӨААТҮГазар сумын Засаг дарга, аймгийн өмчийн газартай гурвалсан гэрээ байгуулж хамтран ажиллана.

2.6. Сум дундын техник эзэмшилдээ авсан ОНӨААТҮГазар техникийг технологийн дагуу засвар үйлчилгээ бүрэн бүтэн байдлыг хангаж, тариаланч иргэдэд сурталчилна.

### Гурав. Сум дундын техникийг ашиглагч ОНӨААТҮГазрын хүлээх үүрэг, хариуцлага

3.1. Сум дундын техник эзэмшилдээ авсан ОНӨААТҮГазар гэрээнд заасны дагуу эд хөрөнгөд засвар үйлчилгээ хийнэ.

3.2. Сумын ОНӨААТҮГазар гурвалсан гэрээ, энэхүү журмын 2.5-т заасны дагуу техник хүлээн авах үүрэгтэй

3.3. Сумын ОНӨААТҮГазар техник ашиглахдаа зориулалтын дагуу чанар байдлыг муутгахгүй бүрэн бүтэн байдлыг хариуцна. Хохирол учруулбал хохирлыг нөхөн төлнө.

3.4. Сумын техникийг өөр суманд дамжуулах, барьцаалах, шилжүүлэх, мөн баталгаа гаргахыг хориглоно.

3.5. Жил бүр үзлэг оношилгоонд бүрэн хамруулж, стандартын шаардлага хангасан үйлчилгээг хариуцан гүйцэтгэнэ.

3.6. Шаардлагатай техник тоног төхөөрөмжийн жагсаалт гарган үнийн мэдээллийг жил бүр шинэчлэн тогтоож, энэ тухай орон нутгийн Засаг дарга болон иргэдийн хуралд мэдэгдэж шийдвэр гаргуулж байна.

3.7. Орон нутаг, бүс, улсын хэмжээний ажилд дайчлан оролцуулж сурталчилна.

3.8 үйлчилгээний хөлс

### **Дөрөв. Механикжуулагчид тавигдах шаардлага**

4.1. Механикжуулагч нь засвар үйлчилгээг хийж болно. Засвар үйлчилгээнд техник тоног төхөөрөмжийн үзлэг, оношилгоо, хэвийн үйл ажиллагааг сайжруулахаар хийгдэж буй засварыг гэж ойлгоно.

4.2. Техникийн бүрэн бүтэн байдлыг хариуцах үүрэгтэй.

4.3. Механикжуулагчийн буруутай үйл ажиллагаанаас техникт учирсан гэмтэл эвдрэл хохирлыг бүрэн хариуцаж, барагдуулах.

4.4. Механикжуулагч нь түрээслэх барьцаалах, баталгаа гаргахыг хориглоно.

4.5 Жил бүр хариуцсан ОНӨААТҮГазартай гэрээ байгуулан хавар, намрын засвар үйлчилгээний, санхүүгийн тайлангаа гаргаж өгөх үүрэгтэй

4.6 Сумын Засаг дарга болон холбогдох байгууллагуудаас гаргасан шийдвэрүүдийн хэрэгжилт, эрх бүхий байгууллагаас тавьсан шаардлагыг биелүүлэх.

### **Тав. Тариаланч иргэдийн хүлээх үүрэг:**

5.1 Сумын тариаланч иргэд тухайн үйлчлүүлж байгаа ОНӨААТҮГазарт захиалга өгөн төлбөр тооцоогоо барагдуулан бүртгэлд хамрагдана

5.2 Бүртгэлийн дагуу захиалгаа шаардах

5.3 ОНӨААТҮГазрын зөвшөөрөлгүй техник авч ашиглахыг хориглоно.

5.4 Газар тариалан эрхлэгч иргэн захиалгаа үнэн зөв гаргаж бүртгэлд хамрагдан дарааллын дагуу үйлчилгээ авна.

### **Зургаа. Журамын хэрэгжүүлэхэд санхүүжилтын талаар**

6.1. Сумын дундын техникийг ОНӨААТҮГазар газар тариалан эрхлэгчдэд төлбөртэй ашиглуулж / үйлчилгээ үзүүлж/ үйл ажиллагааны орлогоор өөрийгөө санхүүжүүлж аж ахуйн бүрэн тооцоонд ажиллана.

6.2. Газар тариалан эрхлэгчдэд ашиглуулах төлбөрийн ОНӨААТҮГазар механикжуулагчтайгаа зөвшилцөн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан үнийн тарифаар тохиролцож гэрээ байгуулж ажиллана. Төлбөрийг тогтоохдоо техникийн үнэлгээ механикжуулагчийн цалин хөлс, шаардагдах эх үүсвэрийг бүрдүүлэх тооцоог үндэслэл болгоно.

6.3. Шинээр авах техникийн зардлыг Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

### **Долоо. ЗДТГазрын үүрэг, хүлээх хариуцлага**

7.1. Сум дундын техникийг иргэдэд ашиглуулахдаа сумын Засаг даргын санал дээр үндэслэн ОНӨААТҮГазарт хүлээлгэн өгөх

- 7.2. ОНӨААТҮГ-ын орлогын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангуулна.
- 7.3. Суманд шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгаа гаргах
- 7.4 Сумын техник ОНӨААТҮГ газар санал болгосноор техникийн акт баримт бүрдүүлэн өмчийн газарт хандах
- 7.5 Сум дундын техник эзэмшилдээ авсан ОНӨААТҮГ газар механикжуулагч хийсэн гэрээнд хяналт тавих
- 7.6 Тоног төхөөрөмжийг зохих зөвшөөрөлгүй өөрчилсөн, эвдэлсэн, гэмтээсэн тохиолдолд хэвийн байдалд оруулах учирсан хохирлыг арилгахыг шаардах

**Найм. Журмын хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага тооцох,  
хохирол нөхөн төлүүлэх:**

- 8.1. Сумын ОНӨААТҮГ газрын бусдад учруулсан хохирлыг ЗДТГазар хариуцахгүй
- 8.2. Сумын ОНӨААТҮГ газрын засварын зардлыг Засаг даргын Тамгын газар хариуцахгүй дагуу хариуцлага тооцно.
- 8.3. Гурвалсан гэрээний үүргийн биелэлтийн хүрээнд харилцан хариуцлага хүлээх бөгөөд нэг тал үүргээ биелүүлээгүй бол биелүүлээгүй үүргийн хэмжээгээр хариуцлага хүлээнэ.